

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 13/380

НШУС

2012

ШОГ, ХОШИН НИЙТЛЭЛИЙГ НУХАЦТАЙ СУДАЛСАН БҮТЭЭЛ

М. Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимиийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: шог, хошин нийтлэл, уламжлал, шинэчлэл, шог найруулал, улс төрийн шог, "Матар", "Хүмүүжил жигшил", "Тоншуул", сэтгүүлчийн ур чадвар

Залуу судлаач, сэтгүүл зүйн доктор Н.Мөнхзоригийн "Монголын шог, хошин нийтлэлийн уламжлал, шинэчлэл" хэмээх нэг сэдэвт зохиолыг олзуурхан уншиж, дараах хэдэн зүйлийг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Судлаач Монголын сэтгүүл зүйд бараг судлагдаагүй, ганц нэг сурталчилгааны өгүүлэл төдийгөөр хязгаарлагдаж байсан, зайлшгүй судлах шаардлагатай сэдвийг сонгон авч, нэг сэдэвт зохиолын хүрээнд судлан шинжилж, өөрийн гэсэн үнэлэлт өгч, санал зөвлөмж дэвшүүлсэн нь нэн сайшаалтай бөгөөд дэмжүүштэй эхлэл юм. Монголын сэтгүүл зүй судлалд бараг цав цагаанаараа байгаа, судлаачаа хүлээж байсан сэдэв бол шог, хошин нийтлэлийн уламжлал, шинэчлэлийн асуудал мөн гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ. Угаасаа шог, хошин нийтлэлийн үүсэл хөгжил, түүнийг сэдэв, агуулга, ур чадвар, дотоод хэлбэрийн хувьд судлах нь тийм ч амар ажил биш бөгөөд олон жилийн

турш манай судлаачид барьж авахаас эмээж, дандаа тойрч гарч байсан юм. Ийм хүнд, хэцүү сэдвийг зориг гарган сонгон авч, нэг сэдэвт зохиолын түвшинд судалсан Н.Мөнхзоригт сэтгүүл зүй судлаач хүний, түүний багшийн хувьд талархал илэрхийлэхийг хүсч байна.

Зохиогч номын нэгдүгээр бүлэгт 1935 онд анхны дугаар нь гарсан нийгэм-улс төрийн шог сэтгүүл "Хүмүүжил ба жигшил"-ээс эхлээд 70 гаруй жилийн туршид "Матар", "Хүмүүжил жигшил", "Тоншуул" болон бусад тогтмол хэвлэлд нийтлэгдсэн 20 шахам сэдвээр бичлэгийн 10 гаруй төрөл, зүйлийн хүрээнд бичигдсэн асар их хэмжээний бүтээлийг нэгбүрчлэн судалж, тэдгээрийг сэдэв чиглэл, бичлэгийн төрөл, зүйлийн хувьд ангилж, үнэлэлт дүгнэлт өгч, ул суурьтай тайлбар хийсэн нь нэн шинэлэг бөгөөд урьд өмнө судалгааны эргэлтэнд орж байгаагүй маш олон баримт сэлтийг анх удаа ашигласан нь энэ сэдвийг цаашид тодорхой асуудал, бичлэгийн зүйл, хэлбэр, цаг хугацааны тодорхой үе шатаар хязгаарлаж, шог, хошин нийтлэлийн гол төлөөлөгчдийн бүтээлүүдийг тусгайлан, гүнзгийрүүлэн судлах боломжийг нээн өгч байгаагаараа

онол, практик, арга зүйн хувьд чухал ач холбогдолтой юм. Мөн энэ хугацаанд шог, хошин нийтлэлийн агуулга ба хэлбэр нь нийгмийн хөгжил дэвшлээс шалтгаалан яаж хувьсан өөрчлөгдөж, эдгээр нийтлэлүүд нь “аливаа өө соготой үзэгдэл, хариуцлага алдсан гэм дутагдлыг давстай шорвог үгээр анагааж, хачиртай инээдээр чимхэж, хорон үгээр хатгаж, өөчлөн жигшүүлснээр” нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж, тэр нь ямар үр дунд хүрч байсныг тод томруун харуулжээ. Нөгөө талаар үүнийг судлаачийн нөр их хөдөлмөр, идэвх зүтгэл, хүчин чармайлтын үр дүн гэж ойлгох хэрэгтэй. Энэ утгаараа Монголын сэтгүүл зүйн шог, хошин нийтлэлийн судлалын эх суурийг тавьсан бүтээл гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

“Шог, хошин нийтлэлийн онцлог, мөн чанарын тухайд” хэмээх хэсэгт онолын ойлголт, тайлбарын хувьд хараахан нэг мөр болоогүй байсан шог нийтлэл, хошин нийтлэл хэмээх ойлголтуудын ялгаатай болон төстэй талуудыг гаргахыг оролдож, тэдний хошин, шог зохиолоос ялгагдах онцлогийг “Шог, хошин нийтлэл нь сэтгүүл зүйн бүтээгдэхүүний хувьд уран сайхны дүр бүтээхийг зорьдоггүй. Түүнчлэн гэм дутагдал бүхий этгээдийн талаар уншигч, үзэгч, сонсогчдод мэдээлэл хүргэхийг чухалчилдаг. Шог, хошин зохиолын дүр нь хэв шинжит, уран сайхны, өөрөөр хэлбэл, зохиомол байдаг. Харин шог, хошин нийтлэлийн дүр нь хувь хүний, бодит байдгаараа ялгаатай. Шог, хошин нийтлэл нь уран сайхны дүрээр хүмүүсийг инээлгэх, хөгжөөх зорилго тавьдаг. Тэгвэл шог, хошин нийтлэл нь дүрээр дамжуулж ямар нэг гэм, дутагдлыг олон нийтээр жигшүүлэх, улмаар хүн, нийгмийн амьдралаас арилгах зорилгоор бичигд-

дэг” гэж зөв зүйтэй гаргаж чадсан байна. Ер нь энэ мэтийн онолын дүгнэлт манай сэтгүүл зүй судлал ихээхэн дутмаг байдаг. Тэр тусмаа одоо л жинхэнэ утгаараа судалгааны объект болж буй шог, хошин нийтлэлийн хувьд ийм дүгнэлт онцгой ач холбогдолтой гэдэг нь тодорхой.

Э л бүтээлийн ихээхэн анхаарал татах асуудлыг тусгасан бүлэг бол “Монголын шог, хошин нийтлэлийн уран чадварын асуудалд” хэмээх хоёрдугаар бүлэг юм. Учир нь Монголын сэтгүүл зүйн судлалд маш бага, утга зохиолын судлалтай харьцуулахад нэлээд өнгөцхөн, тойм төдий судлагдсан асуудал бол нийтлэл, нэвтрүүлгийн уран чадварын асуудал мөн. Судлаач Л.Норовсүрэн, Т.Баасан-сүрэн болон энэ мөрийг бичигчийн зарим бүтээлийг эс тооцвол ур чадварын талаар бичигдсэн тоймтой бүтээл алга байна. Нөгөө талаар ур чадварын талаар бичигдсэн зарим бүтээл тухайн бүтээлийн зөвхөн ололтой талыг гаргахыг зорилго болгосон, шүүмжлэлтэй хандах талаар ихээхэн дутагдалтай байдаг. Тиймээс шог, хошин нийтэлийн уран чадварын асуудлыг нэг сэдэвт зохиолын бүлгийн хэмжээнд судалж, ялангуяа шог, хошин нийтлэлийн Ц.Дамдинсүрэн, Л.Бадарч, Ц.Цэнджав, Ш.Жамбалсүрэн, Б.Авирамэд, Даг. Жамъян, Д.Гармаа, Б.Бааст, Н.Иштавхай, Н.Цэвэгмид, Л.Лодоншаарв, Ц.Доржготов, Ж.Барамсай, Шаг. Цэнд-Аюуш, М.Гүрсэд, Б.Цэнддоо, Н.Даваадаш, А.Амарсайхан, Д.Баясгалан зэрэг үе үеийн гол төлөөлөгчдийн нийтлэл, өгүүллэгүүдэд дүн шинжилгээ хийж, ололтой болон дутагдалтай талыг гаргаж, өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт хийсэн нь нэн шинэлэг болжээ. Зохиогч “1990 оноос хойш эдгээр сэтгүүлчдийн шог, хошин нийтлэлүүд ихэнхдээ

амьдрал, нийгэмд оршиж байгаа дутагдал, эрх баригчдын удирдлагын арга барилын доголдол, удирдах, зохион байгуулах менежментийн алдаа завхрал, хоосон амлалт, хууран мэхлэлт, улс төрийн хүчинүүд ард түмний "тархи угааж" байгаа явдал, тэдний атаа хорсол, тулга тойрсон арчаагүй хэрүүл, тэмцэл, юунд ч ханаж цадашгүй ховдог шунахай сэтгэл, цаашлаад залхуучууд, архичдыг элэг-лэсэн, егөөдсөн өнгөяястай байна. Тэдний нийтлэлүүд шог найруулал, шог, хошин өгүүллэг, хошин, ёпт үлгэр, наргиа, хошин мэдээ, ёргио үг, шог яриа, элэглэл гэх мэт бичлэгийн олон төрөл, зүйлийг хамарсан байдаг. Түүнээс гадна шог, хошин, ёпт хэлбэрээр бичигдсэн

ерөөл, ярилцлага, зурхай, эргэцүүлэл, танилцах зар, үгийн сүлжээ, мэндчилгээ нийтлэгдэж байв. 1990 он гарснаар манай сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл явцуурч, нэг хэсэг нь ижилсэж, дундаж саарал холимог нийтлэлүүд бий болсон энэ үед манай шог, хошин нийтлэл бичлэгийн зүйлээ хадгалж үлдсэн нь дэвшилттэй юм" гэсэн зөв дүгнэлт хийсэн байна.

Судлаач 1990 оноос хойш шог, хошин бичлэгт гарсан өөрчлөлт, шинэчлэлийн асуудалд нэлээд нухацтай хандаж, үүнийг "баатар" буюу дүр сонголт, сэдэв, бичлэгийн төрөл, зүйл гэсэн гол гурван хүрээнд авч үзсэн нь арга зүйн хувьд оновчтой болжээ. Чөлөөт хэвлэлийн эх суурь тавигдаж, манай сэтгүүлчид аливаа асуудалд

нэлээд чөлөөтэй хандаж, сэтгэж, бичдэг болсон нь шог, хошин сонголт, дүрийн асуудалд хүчтэй судлаач үүнийг тодорхой жишээ баримтын үндсэн дээр гаргаж, гархай ажиглалт хийсэн нь нэг сэдэвт зохиолоос тодорхой харагдаж байна. Энэ бол судлаач цуглуулсан эх материалыг өөрийн болгож чадсаны, бас судалгааны ажилд бүтээлчээр хандаж, "долоо хэмжиж нэг огтолсон"-ы, орчин үеийн сэтгүүл зүйн судлалд түгээмэл ашиглаж байгаа контент-анализ, логикийн дүн шинжилгээ, харьцуулан судлах, баримт мэдээлэл боловсруулах аргуудыг оновчтой ашигласны үр дүн мөн.

«

Судлаач Монголын сэтгүүл зүйд бараг судлагдаагүй, ганц нэг сурталчилгааны огуулэл төдийгоор хязгаарлагдаж байсан, зайлшгүй судлах шаардлагатай сэдвийг сонгон авч, нэг сэдэвт зохиолын хүрээнд судлан шинжилж, өөрийн гэсэн үнэлэлт өгч, санал зөвлөмж дэвшүүлсэн нь нэн сайшаалтай богоод дэмжүүштэй эхлэл юм.

»

Судлаач Н.Мөнхзориг 1935 оноос хойш гарсан шог, хошин сэтгүүл болон бусад тогтмол хэвлэлд нийтлэгдсэн бүх шог, хошин нийтлэлийг тоймлон гаргах, агуулга ба хэлбэрт нь өнгөхэн хандах зорилго тавиагүй бөгөөд шог, хошин сэтгүүл зүйн үүсэл, хөгжлийн түүхийг 1913-1934 он буюу шог, хошин нийтлэлийн үндэс тавигдсан бэлтгэл үе, 1935-1960 он буюу шог, хошин сэтгүүл зүй үүсч, хөгжсөн үе, 1961-1989 он буюу шог, хошин сэтгүүл зүйн төлөвшлийн үе, 1990 оноос хойш шог, хошин сэтгүүл зүйн өөрчлөлт, шинэчлэлийн үе гэж ангилсан нь тусгаж буй асуудалд хандах харьцангуй шинэлэг хандлага гэж хэлж болно. Мөн 1940-1980 оны үед манай тогтмол хэвлэлд

шог нийтлэл давамгайлж байсан бол 1990 оноос хойш хошин нийтлэл зонхилох болсон гэсэн сонирхолтой дүгнэлт хийж, үүнийг сэтгүүл зүйн үүрэг, зорилгод гарсан өөрчлөлттэй холбон тайлбарласан байна. Түүнчлэн ардчилсан хувьсалаас хойш хоршоны дарга, нэгдлийн орлогч, улсын аж ахуйн газрын нарийн бичгийн дарга, сумын дарга, малын бага эмч, малчин, цахилгаанчин зэрэг хүмүүсийг элэглэсэн шог, хошин нийтлэл сонин сэтгүүлийн хуудаснаас нэгмөсөн арчигдан алга болж, харин үүний оронд ерөнхийлөгч, ерөнхий сайд, УИХ-ын болон засгийн газрын гишүүд, яам тамгын газрын дарга нарыг нийтлэлийн "баатар" болгох хандлага өргөн дэлгэрч, ардчилсан хувьсалаас хойш урьд өмнө байгаагүй цоо шинэ сэдвүүд гарч ирснийг нийгэм-улс төрийн байдалтай холбон тайлбарлажээ. Шог, хошин нийтлэлийн уран чадварын уламжлал, шинэчлэлийн талаар хийсэн судалгаанд тулгуурлан: "...хуучин үед төлөөлөл, хүншүүллийн аргыг түгээмэл хэрэглэж байсан, шүүмжлэгч нь эзэн биегүй, эсвэл адгуус амьтан, амьгүй эд үйл байсан бол өдгөө энэхүү уламжлал халагджээ. ...Шинэчлэл түүнчлэн сэд-вийн хүрээнд явагдсан байна. ...Шүүмжлэлийн үзүүр доошоо чиглэгдэж байсан бол одоо дээшээ чиглэлтэй болжээ. Энэ нь шог, хошин нийтлэлийн баатрын сонголтоос тодорхой харагддаг. Мөн өмнөх үед шог, хошин нийтлэлийн зорилго нь гэм, дутагдлыг устгах явдал байсан бол өнөөгийн нийтлэлүүд засч залруулахад чиглэгдсэн, хүнлэг, энэрэнгүй үзэл нэвтэрсэн

байдал ажиглагддаг" гэж дүгнэжээ. Залуу судлаачийн бүтээлд энэ мэтийн сонирхолтой, зоригтой, анхаарч үзүүштэй улам гүнзгийрүүлж судлууштай дүгнэлт, шинэлэг санаа олон байна. Энэ бол Н.Мөнхзоригийн судалгааны бүтээлийн гол ололт мён.

Э Цэст нь дүгнэж хэлэхэд шог, хошин нийтлэлийн үүсэл, хөгжил, төлөвшил, уламжлал ба шинэчлэлийн асуудлыг агуулга, хэлбэр, ур чадварын хувьд цаг хугацааны өргөн хүрээнд судалж, шинэлэг санаа дэвшиүүлж, үнэлэлт дүгнэлт өгсөн, Монголын шог, хошин сэтгүүл зүйн судлалын эхийг тавьж, цаашид гүнзгийрүүлж судлах үүд хаалгыг нээж өгсөн чамбай бүтээл болсныг онцлон тэмдэглээд Н.Мөнхзоригийн энэхүү бүтээл нь булган сүүлтэй байж, араасаа олон сайхан бүтээл дагуулах болтугай гэж ерөөе.

Резюме

Настоящая рецензия посвящена монографии молодого исследователя, доктора журналистики (Ph.D) Н.Мөнхзорига "Традиции и новаторство мастерства сатирических публикаций периодической печати Монголии", являющейся первой попыткой комплексного исследования сатирических публикаций монгольской журналистики. Автор, высоко оценивая достоинство этой работы, отмечает, что научные выводы и богатые фактические материалы, первоисточники, использованные в данной работе, являются прочным фундаментом и методологической базой для дальнейшего исследования сатирической журналистики нашей страны.